**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Ховд аймгийн Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан**

**Аудитын код:** ХОА-2026/009/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: Ц.Аззаяа<br>Утас:70432545<br>Цахим хаяг: azzayats@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 163

танай__________-ны №__________-т

ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.АЛТАНЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 445 хүүхэд суралцаж байгаагаас хамран сургах тойргийн 321 хүүхэд буюу 62 хувь, 124 хүүхэд бусад тойрогт суралцаж байна. Тус сургууль нь дотуур байртай хөдөө орон нутгийн хүүхдүүд суралцаж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд цалин хөлсний зардалд 1,884,820.9 мянган төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 19.4 хувиар, үдийн хоолны зардалд 65,711.4 мянга, тогтмол зардалд 221,817.5 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд

8426050373

52,541.8 мянган төгрөгийг зарцуулсан нь 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 13.1 хувиар тус тус өссөн нь төрийн албан хаагчийн цалин, хүүхдийн хоолны зардлын норматив, цахилгаан, халаалтын үнэ тариф өссөнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлийг тооцон дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

2025 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшинд 3 багш, II түвшинд 3 багш, III түвшинд 7 багш, IV түвшинд 8 багш үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **227,167,495.7** | **186,430,418.5** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 82,758,651.6 | 37,610,255.6 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 82,758,651.6 | 37,610,255.6 |
| **3121** | **Төгрөг** | 82,758,651.6 | 37,610,255.6 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 82,758,651.6 | 37,610,255.6 |
| **33** | **АВЛАГА** | 628,019.0 | 898,047.7 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 25,085.0 | 295,113.8 |
| **335** | **Бусад авлага** | 602,934.0 | 602,934.0 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 300,000.0 | 300,000.0 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 302,934.0 | 302,934.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 143,780,825.1 | 147,922,115.2 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,632,300.0 | 1,632,300.0 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,632,300.0 | 1,632,300.0 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | 2,504,270.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 142,148,525.1 | 143,785,545.2 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 10,561,580.0 | 11,674,880.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 97,623,881.5 | 100,300,566.5 |
| 35460 | Хүнсний материал | 7,084,096.2 | 457,806.2 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 26,878,967.4 | 31,352,292.4 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,851,473,585.5** | **1,742,865,178.3** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,851,473,585.5 | 1,742,865,178.3 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,802,273,585.5 | 1,693,665,178.3 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,676,101,143.3 | 1,676,101,143.3 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (353,221,350.8) | (420,721,291.7) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 443,691,508.2 | 381,172,673.2 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (158,304,843.0) | (154,153,710.8) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 254,206,696.1 | 267,267,843.1 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (91,211,563.9) | (87,013,474.3) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,970,000.0 | 2,970,000.0 |
| 39217 | Ном | 28,041,995.5 | 28,041,995.5 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 49,200,000.0 | 49,200,000.0 |
| 39301 | Програм хангамж | 689,500.0 | 689,500.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (689,500.0) | (689,500.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 49,200,000.0 | 49,200,000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,078,641,081.1** | **1,929,295,596.8** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **85,271,511.6** | **81,174,118.0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 85,271,511.6 | 81,174,118.0 |
| **413** | **Өглөг** | 85,271,511.6 | 81,174,118.0 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 381,900.0 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,375,850.0 | 680,900.0 |
| **4136** | **Бусад өглөг** | 83,513,761.6 | 80,493,218.0 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 83,163,134.6 | 80,142,591.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 350,627.0 | 350,627.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,180,201,647.6** | **1,034,953,556.7** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,180,201,647.6 | 1,034,953,556.7 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 325,593,523.9 | 180,345,433.0 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 325,593,523.9 | 325,593,523.9 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (145,248,090.9) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 854,608,123.7 | 854,608,123.7 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,265,473,159.1** | **1,116,127,674.8** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,156,330,933.0** | **2,608,230,406.0** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **32,609,333.0** | **72,794,106.0** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 32,609,333.0 | 72,794,106.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 32,609,333.0 | 72,794,106.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,833,933.0 | 2,592,000.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,775,400.0 | 25,509,236.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 44,692,870.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,123,721,600.0** | **2,535,436,300.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,006,354,700.0 | 2,308,759,800.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,006,354,700.0 | 2,308,759,800.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 117,366,900.0 | 226,676,500.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 117,366,900.0 | 226,676,500.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,218,411,666.4** | **2,753,478,496.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,218,411,666.4** | **2,753,478,496.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,173,221,366.4 | 2,679,475,817.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,578,230,235.2 | 1,888,350,220.6 |
| 210101 | Үндсэн цалин | 958,588,032.1 | 1,069,633,933.2 |
| 210102 | Нэмэгдэл | 555,562,343.1 | 704,294,337.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 51,924,100.0 |
| 210104 | Урамшуулал | 64,079,860.0 | 62,497,850.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 197,856,419.5 | 234,840,460.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 134,888,492.9 | 161,376,926.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,960,135.3 | 18,508,212.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,842,550.8 | 9,465,334.2 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,127,837.9 | 9,325,255.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,037,402.6 | 36,164,731.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 112,842,460.0 | 220,811,180.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,776,350.0 | 21,444,650.0 |
| 210302 | Түлш, халаалт | 94,193,610.0 | 198,678,530.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 872,500.0 | 688,000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 48,804,400.0 | 67,284,640.0 |
| 210502 | Хоол, хүнс | 48,804,400.0 | 67,284,640.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,250,000.0 | 5,532,350.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,250,000.0 | 5,532,350.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 28,646,643.6 | 44,113,801.1 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,460,400.0 | 2,695,300.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,186,243.6 | 41,418,501.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 203,591,208.0 | 218,543,165.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,885,600.3 | 52,086,312.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,351,450.0 | 6,957,900.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 146,354,157.7 | 159,498,952.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 45,190,300.0 | 74,002,679.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,189,510.0 | 73,943,710.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 45,189,510.0 | 67,026,310.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 6,917,400.0 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 790.0 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 790.0 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 58,969.5 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 58,969.5 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(62,080,733.4)** | **(145,248,090.9)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,143,613.3 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,143,613.3 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (2,143,613.3) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(64,224,346.7)** | **(145,248,090.9)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 813,167,922.0 | 854,608,123.7 | 325,593,523.9 | 1,993,369,569.6 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 813,167,922.0 | 854,608,123.7 | 325,593,523.9 | 1,993,369,569.6 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 813,167,922.0 | 854,608,123.7 | 325,593,523.9 | 1,993,369,569.6 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 813,167,922.0 | 854,608,123.7 | 325,593,523.9 | 1,993,369,569.6 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 813,167,922.0 | 854,608,123.7 | 325,593,523.9 | 1,993,369,569.6 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (145,248,090.85) | (145,248,090.85) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 813,167,922.0 | 854,608,123.7 | 180,345,433.02 | 1,848,121,478.74 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | 2,156,330,933.0 | 2,563,537,536.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 32,609,333.0 | 28,101,236.0 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 32,609,333.0 | 28,101,236.0 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 32,609,333.0 | 28,101,236.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,833,933.0 | 2,592,000.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 17,775,400.0 | 25,509,236.0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 2,123,721,600.0 | 2,535,436,300.0 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,006,354,700.0 | 2,308,759,800.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,006,354,700.0 | 2,308,759,800.0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 117,366,900.0 | 226,676,500.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 117,366,900.0 | 226,676,500.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 2,068,238,133.6 | 2,608,685,932.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,068,238,133.6 | 2,608,685,932.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,019,625,243.6 | 2,535,229,562.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,578,483,339.7 | 1,884,820,961.3 |
| 210101 | Үндсэн цалин | 939,010,331.4 | 994,220,797.6 |
| 210102 | Нэмэгдэл | 571,950,203.6 | 776,727,100.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 51,778,175.9 |
| 210104 | Урамшуулал | 67,522,804.7 | 62,094,887.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 197,628,400.0 | 237,986,548.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 134,387,400.0 | 161,703,648.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,810,200.0 | 19,070,500.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,905,100.0 | 9,535,600.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,905,100.0 | 9,535,600.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,620,600.0 | 38,141,200.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 112,116,110.0 | 221,817,530.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,270,000.0 | 22,451,000.0 |
| 210302 | Түлш, халаалт | 93,973,610.0 | 198,678,530.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 872,500.0 | 688,000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 36,695,800.0 | 52,541,840.0 |
| 210502 | Хоол, хүнс | 36,695,800.0 | 52,541,840.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,250,000.0 | 4,800,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,250,000.0 | 4,800,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 30,928,143.6 | 29,125,992.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,741,900.0 | 2,695,300.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,186,243.6 | 26,430,692.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 60,523,450.3 | 104,136,689.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,896,300.3 | 94,498,789.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,627,150.0 | 9,637,900.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,612,890.0 | 73,456,369.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 48,612,100.0 | 73,397,400.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 48,612,100.0 | 65,711,400.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,686,000.0 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 790.0 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 790.0 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 58,969.5 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 58,969.5 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 88,092,799.4 | (45,148,396.0) |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 61,499,704.5 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 61,499,704.5 | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 61,499,704.5 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 61,499,704.5 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | (61,499,704.5) | - |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 26,593,094.8 | (45,148,396.0) |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 82,758,651.6 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 82,758,651.6 | 37,610,255.6 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,671,949,560.0 | 2,608,685,932.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,671,949,560.0 | 2,608,685,932.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,603,643,760.0 | 2,542,974,532.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,926,569,500.0 | 1,884,820,961.3 |
| 210101 | Үндсэн цалин | 1,142,054,000.0 | 994,220,797.6 |
| 210102 | Нэмэгдэл | 738,217,900.0 | 776,727,100.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 51,778,175.9 |
| 210104 | Урамшуулал | 46,297,600.0 | 62,094,887.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 241,021,900.0 | 237,986,548.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 163,894,900.0 | 161,703,648.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,281,700.0 | 19,070,500.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,640,900.0 | 9,535,600.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,640,900.0 | 9,535,600.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,563,500.0 | 38,141,200.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 221,876,500.0 | 221,817,530.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,451,000.0 | 22,451,000.0 |
| 210302 | Түлш, халаалт | 198,737,500.0 | 198,678,530.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 688,000.0 | 688,000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 57,023,500.0 | 52,541,840.0 |
| 210502 | Хоол, хүнс | 57,023,500.0 | 52,541,840.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,800,000.0 | 4,800,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,800,000.0 | 4,800,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,679,000.0 | 29,125,992.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,798,600.0 | 2,695,300.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 26,880,400.0 | 26,430,692.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 122,673,360.0 | 111,881,659.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,990,060.0 | 102,243,759.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,683,300.0 | 9,637,900.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 68,305,800.0 | 65,711,400.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 68,305,800.0 | 65,711,400.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 68,305,800.0 | 65,711,400.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,671,949,560.0 | 2,563,537,536.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,333,267,400.0 | 2,308,759,800.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,333,267,400.0 | 2,308,759,800.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 226,676,500.0 | 226,676,500.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 226,676,500.0 | 226,676,500.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 112,005,660.0 | 28,101,236.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,695,300.0 | 2,592,000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 33,625,000.0 | 25,509,236.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 75,685,360.0 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 82,758,651.6 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 37,610,255.6 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,889.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 4 зөрчил[1] илэрснээс 2,960.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 3,929.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### 3.1. ТӨЛБӨРИЙН АКТ

*3.1.1. Илрүүлэлт:* Аудитаар байгууллагын удирдлага нь нягтлан бодогч, нярав нарын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус урамшуулалтай давхардуулан санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 1 сарын цалингийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төлбөрийн акт тогтоов.

*3.1.2 Илрүүлэлт 2:* Боловсролын газрын дарга хагас бүтэн жилээр ур чадварын нэмэгдэл олгох тухай тушаал гаргасан байхад сумын Засаг даргын захирамжаар 3 сарын ур чадварын нэмэгдэл давхардуулан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын “3. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төлбөрийн акт тогтоов.

### 3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *3.2.1 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал*

*Илрүүлэлт:* Гэрэл цахилгааны зардлыг бараа үйлчилгээний зардлын данснаас 3,031.3 мянган төгрөг төлсөн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; Төсвийн тухай хуулийн 22.1. “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Тогтмол зардлын ангиллын дагуу санхүүжүүлж ажиллах, Сангийн сайдын 2025 оын А/03 дугаар тушаалаар батлагдсан " Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг мөрдөн ажиллах.

### *3.2.2 Авлага, өглөгтэй холбоотой асуудал*

*Илрүүлэлт*: Авлага, өр төлбөрийг бууруулах арга хэмжээ аваагүй урд оноос авлага 270.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* 2026 онд байгууллагын дансанд бүртгэлтэй авлага, өглөгийг бууруулах арга хэмжээ авах,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* */мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Буянт сумын ерөнхий боловсролын сургууль | Гэрэл цахилгааны зардлыг бараа үйлчилгээний зардлын данснаас төлсөн. | 1 | 3,031.3 | | | | | 1 | 3,031.3 | | |
| | Авлага өглөгийг бууруулах арга хэмжээ аваагүй. Авлага урд оноос өссөн үзүүлэлттэй байна. | 1 | 898.0 | | | | | 1 | 898.0 | | |
| | Боловсролын газрын дарга хагас бүтэн жилээр ур чадварын нэмэгдэл олгох тухай тушаал гаргасан байхад сумын Засаг даргын захирамжаар 3 сарын ур чадварын нэмэгдэл давхардуулан авсан. | 1 | 818.5 | 1 | 818.5 | | | | | | |
| | Нягтлан бодогч, нярав нарт үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон. | 1 | 2,141.8 | 1 | 2,141.8 | | | | | | |
| **Нийт дүн** | | **4** | **6,889.7** | **2** | **2,960.3** | | | **2** | **3,929.3** | | |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |